

# 1

## МРНГРО УЛСЫН САНХҮҮ, ТӨСВИЙН АЛБА, ТҮҮНИЙ ХӨГЖЛИЙН ТОВЧ ТОЙМ

---

**Н.Агваан**

Монгол улсын санхүү төсвийн албаны XX-XXI зууны түүхэн хөгжлийн эхлэл үеийг ард түмний үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцэл хийж, төр улсаа сэргээж, тусгаар тогтнолоо тунхагласан 1911-1912 он гэж энэхүү өгүүлэлд тэмдэглэж байна. Ингэж тэмдэглэхийн түүхэн үндэслэл баримт бичиг нь Монгол Улсын Их Сургуулиас 2000 онд хэвлүүлсэн "Монгол улсын санхүүгийн албаны түүх" ном бөгөөд тус номонд "Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, хаан эзнээ өргөмжилж, төрийн таван яам байгуулсаны нэг Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэх яам юм." гээд 1991 оны 12-р сарын 29-ний өдөр эдгээр яамдын сайд түшмэдийг томилон ажиллуулсан тухай өгүүлжээ.

Энэ цаг үеэс Богд хаант Монгол улсын Засгийн газрын өмнө хувиа аргацаасан мал аж ахуйтай, үндэсний томоохон үйлдвэрлэл хөгжөөгүй, худалдаа арилжаа хийж зах зээлд төлбөрийн хэрэгсэл болсон мөнгөн тэмдэгт хэрэглэх ажиллагаа нэвтрээгүй эдийн засгийн хоцрогдмол хөгжилтэй улс орноо өөд нь татаж, санхүү, төсвийн үндэсний системийг бий болгож хөгжүүлэх томоохон зорилт тулгарсан байна. Ийм зорилтыг биечлэн хэрэгжүүлэх үүргийг мэдээж хэрэг шинээр байгуулагдсан Сангийн яам гардан гүйцэтгэхээр хүлээн авсан бөгөөд гадаад, дотоодын олон хүчин зүйлийн эсэргүүцэлтэй тулгарч тэдгээрийг давж гарсан билээ.

Тухайн үеэс Монгол улсын Сангийн яам өөрийн бүтэц зохион байгуулалтаа шинэчлэн эхэлж, үүрэг зорилтоо дүрэмдээ тодорхойлон доорх чиглэлийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн байна. Үүнд:

**1. Сангийн мөнгийг хадгалах.** Улсын сан хөмрөг, санхүүгийн эд зүйлсийг хадгалах, газар дэлхийн баялгыг шинжлэн судлах, түүнийг хэрхэн ашиглаж улсын сан хөмрөг арвижуулахад яаж туслан тодорхойлж зарцуулах дүрэм мөрдөж хэрэгжүүлэхээс эхлэн зохион байгуулагдаж байв.

**2. Улсын төсвийн орлого зарлагын төсөв зохиох нь** тэр үеийн Монгол улсын Сангийн яамны үйл ажиллагаанд үндсэн зорилт болж байлаа. Улсын орлого зарлагын төсвийн эх сурвалжийг баталгаажуулахад дан ганц гадаад орноос авах зээл найдвартай бус байсан учир 1913 онд Халхын дөрвөн аймгийн чуулганы төлөөлөгчид, засаг ноёд, дээд тушаалын түшмэдүүдийн хамт хуралдан зөвлөж бүх аймагт алба гувчуур ногдуулан төлүүлэх хэмжээг тодорхойлсон байна. Энэ нь улсын төсөвт төлөх нэмэр болж байсан боловч санхүүгийн бүх хэрэгцээг хангах бололцоог бүрдүүлж бүрэн чадахгүй байсан юм. Гэхдээ л 1911-1919 оны Монгол улсын Санхүү төсвийн гол эх сурвалж нь татвар хураамж байсан.

Монгол улсын төсөв эхнээсээ улсын төсөв, орон нутгийн төсөв гэсэн хоёр заагтай байж, нийт орлогын 80 орчим хувь улсын төвлөрсөн төсвийг бүрдүүлдэг байсан бололтой.

**3. Төсвийн мөнгөн тооцоо бүртгэлийг данслах, хөтлөх, тайлагнах.** Энэ ажлыг Сангийн яам анхааран гүйцэтгэж байжээ. Ингэж гүйцэтгэхдээ төсвийн орлого болоод зарлагыг рублээр голчлон бүртгэж дансладаг байжээ. Үүний учир нь тухайн үед Монголын эдийн засагт Орос рубль нэлээд эрэлт хэрэгцээтэй байж, Хятад янчиан, Америк доллараас илүү гүйгдэж нэг лан мөнгө, рублийн хоорондын харьцаа тэнцэж байсан байна. Гэхдээ энэхүү бүртгэл данс энгийн бөгөөд зөвхөн татвар ноогдуулалт, орлого хуваарилалтын хүрээнд лан мөнгө, эд хөрөнгө, мал амьтад, мах сүү цагаан идээгээр хүртэл тооцогдож байжээ. Энэ нь төсвийн тогтолцоо бүрэн төлөвшиж чадаагүй эхлэлийн үедээ байсны гэрч юм. Тухайлбал төсвийн жилийн зөвхөн орлого талыг Богд эзэн хаанд өргөн мэдүүлэхээс зарлагын нарийвчилсан хуваарилалт, зарцуулалт, үр дүнгийн талаар тодорхой тайлагнах журам хараахан төлөв-шөөгүй байлаа.

**4. Мөн улсын санхүү төсвийг бүрдүүлэх** гол эх сурвалж болсон албан татвар хураалт, улсын эрдэнэсийн санд хадгалж буй алт мөнгө зэрэг үнэт зүйлсийн үнэлгээ, хадгалалт зарцуулалтад хяналт тавих ажил Сангийн яамнаа гүйцэлдүүлж байв. Засгийн газрын болоод Яамдын орон тоо, цалин пүнлүү захиргаа аж ахуйн зардлыг тогтоон өгч, хуваарилах, гүйцэтгэлд нь хяналт тавих ажлыг Сангийн яам эрхэлдэг байв. Бас 1911 онд шинэ тутам байгуулагдсан Монгол улсын эдийн засаг мөнгөн санхүүгийн эх үүсвэр болсон албан татварыг ноогдуулах гол зарчмыг насанд хүрсэн бүх эрчүүдийг 150 хүнээр бодож сум болгон тооцож тодорхой хэмжээний албыг аймагт нь хуваарилдаг бөгөөд аймаг нь хошууд, хошууд нь харъяат ардынхаа малын тоонд уул албыг оногдуулдаг хэлбэрээр мөрдөж эргэж энэ журмаа гүйцэтгэлийг хянадаг байжээ.

Ийм байдлаар Богд хаант Монгол улсын санхүү төсвийн алба үүсэн байгуулагдаж үйл ажиллагаа нь 1921 онд ялсан ардын хувьсгалын дараа шинэ агуулга хэлбэрээр үргэлжлэн хөгжсөн юм. Түүхчид Монгол улсын санхүү төсвийн албаны эхлэлийг тодорхойлохдоо: "1911-1921 он бол Монгол улсын түүхийн онцгой зурвас үе бөгөөд энэ хугацаанд монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээж, улс гэрээ төвхнүүлэхийн төлөө ялангуяа эдийн засаг, санхүү аж ахуйгаа хөгжүүлэх, улс шиг улс болохын төлөө үнэхээр амс хийх чөлөөгүй хүчин зүтгэсэн билээ. Улсынхаа хүү, санг бүрдүүлэхийн тулд бүх нөөц бололцоогоо дайчилж ёстой хуруу хумсаа хуйхлахаас наахнуур хичээж чармайж байлаа. Үүнийхээ ч үрээр эх Орос улсаас хатуухан болзолтой зээл авч, төрийн алба, гааль, татварын орлогоо арвилан хэмнэж, газрын хэвлийн баялгаа түрээслэж мөнгө санхүүгийн хэрэгцээгээ бүрэн бус боловч хангаж байлаа." гэжээ.

Тэгвэл энэ нь Монголын үндэсний хувьсгалыг ялалтад хүргэж түүний санхүү эдийн засгийн нөхцлийг бүрэн хангах үүргийг шинээр байгуулагдсан ардын түр засгийн газрын Санхүүгийн алба (1921.03.24-нд Монгол Ардын намын төв хорооны намын дарга, гишүүдийн хамтарсан хурлаар Дотоод, Цэрэг, Сангийн гэсэн гурван яамыг байгуулжээ)-ны үндэслэл болж, ийм үйл ажиллагааг эрхэлдэг төр засгийн байгууллага зайлшгүй шаардлагатай гэсэн ойлголтыг

тодорхойлж өгсөн хэрэг юм. Ийнхүү ардын түр засгийн газрын санхүүгийн алба буюу хожмын Сангийн яам нь шинэ нөхцөл байдалд зохион байгуулагдаж бий болсон цагаасаа Монгол улсын төр засгийн өмч хөрөнгийг сахин хамгаалах, бүртгэж хуваарилахын хамт, зарцуулалтад нь хяналт тавих ажилд шамдан орсон байна.

Монгол улсын үндэсний ардчилсан хувьсгал ялалтад хүрч цаашид улс орноо төвхнүүлэх их ажлын эхлэлийн хүрээнд Сангийн яамны гүйцэтгэж байсан үүргийг манай түүхчдийн бүтээсэн (Монгол улсын санхүүгийн албаны түүх) (1921-1996) оны номонд: "Ардын засгийн эдийн засаг, санхүүгийн төв алба Сангийн яам анх үүсч байгуулагдсанаасаа эхлэн 1925 он хүртэл өөрийн үндсэн үүрэг санхүү зээлийн бодлогын боловсруулалт, зохицуулалтын зэрэгцээгээр худалдаа бэлтгэл, гадаад эдийн засгийн харилцаа, улсын мөнгөн гүйлгээ (банк)-ний ажил үүргийг давхар гүйцэтгэж Засгийн газрын санхүү, аж ахуйн ажлыг хариуцаж байв." гэж дүгнэжээ. Гэхдээ энэ дүгнэлтийн цаана улсын эдийн засаг, аж ахуйн талын аливаа нэг асуудал хөндөгдөх, үүнтэй холбоотойгоор байгууллага газар үүсэн бий болох бүрд Сангийн яаманд тэр бүхэн нь тохогдох болсон сөрөг үзэгдэл харагдаж байгаа юм.

Ийм байдлыг тухайн үеийн төр засгийн удирдлагууд шүүн хэлэлцээд Сангийн яам БНМАУ-ын Санхүүгийн албыг бэхжүүлж, үндэсний мөнгө зээлийн тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй болохыг тодорхойлж энэ зүгт чиглүүлж төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн төв гэдэг талаар шийдвэр гаргасан байна. Энэ дашрамд нэгэн зүйлийг тэмдэглэхэд тусгаар тогтносон Монгол улсын Санхүү төсвийн албаны үүсэн байгуулагдсан хугацааг бид 1911 оны 12 сарын 29-ны өдрөөр тогтоож ойлгох нь зүйтэй юм. Харин Монгол улсын хөгжлийн цаг үе бүхэн (Ардын хувьсгалын ялалтын дараа, Социализмын бүтээн байгуулалтыг өрнүүлсэн он жилүүдэд, хожим бий болсон өөрчлөлт шинэчлэлтийн энэ үе гэх мэт) -д улсын санхүү төсвийн албаны бодлого, зорилго, хэлбэр зохион байгуулалт өөрчлөгдөж байснаас агуулгын хувьд хөдөлбөргүй тогтвортой үргэлжилж ирсэн байна.

Өөрөөр хэлбэл Манжийн дарлалд 200 гаруй жил талхилуулсан Монголын ард түмэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг зохион байгуулж тусгаар тогтносон Богд хаант Монгол улсаа тунхаглаж, түүнээс арваад жилийн дараа үндэсний ардчилсан хувьсгалыг өрнүүлэн засгийн эрхийг ард түмний гарт шилжүүлснээр тусгаар улсаа бие даалган хөгжүүлж өнөөгийн цаг үетэй золгож байна. Монгол орны нийгэм эдийн засгийн хөгжил дэвшлийн XX зуун (1911.12.29-нөөс эхлэн)-ы түүхэн цаг үе бол бүхэлдээ тус улсын санхүү төсвийн албаны үүсэл хөгжлийн орон зайд хамааралтай болно.

Монгол ардын хувьсгалын ялалтын дараах он жилүүдэд, ялангуяа 1924 оноос улсын нийгэм улс төр, эдийн засгийн зохион байгуулалтын үйл ажиллагааг санхүү төсвийн удирдлагаар ханган бэхжүүлэхтэй холбогдсон олон тодорхой ажлуудыг гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

**Нэгдүгээрт:** БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуульд "Улсын орлого зарлагын эрхийн тухай" зааж улсын санхүүгийн албаны үйл ажиллагааны хууль эрхийн үндэс бий болжээ. Анхдугаар үндсэн хуулийн тавдугаар бүлэгт "...тус улсын аливаа орлого зарлагыг бүх улсын төсөвлөсөн дансанд нэгтгэвэл зохино, улсын төсвийг Улсын Их Хурал, Онцгой хэрэг учир тохиолдвол Улсын Бага хурал батлах, улсын төсөвт тусгагдаагүй ба тусгай дүрэм гаргаж зөвшөрөөгүй бол ямар ч зүйлд улсын сангаас хөрөнгө зарцуулахгүй байх, Улсын Их буюу Бага хурлаас ямар зүйлийн орлого, зарлагыг улсын төсөвт, ямар зүйлийг орон нутгийн төсөвт оруулах, тухайн орон нутгаас төсөвтөө оруулах зүйлийг тогтооно." гэх зэргээр улсын санхүү төсвийн гол зарчмуудыг хуульчлан баталгаажуулсан байна.

**Хоёрдугаарт:** Үндсэн хуулийн дурдсан заалтуудад үндэслэн Сангийн яамнаас 1925 онд улсын төсвийн төлөвлөгөөг төсвийн орлого ба зарлагын зүйлээр нь анх удаагаа ангилан боловсруулж Улсын Бага хурлаар баталгаажуулан мөрджээ.

**Гуравдугаарт:** Дээрх арга хэмжээтэй уялдуулан улсын жин хэмжүүрийн нэгдсэн систем тогтоож, төсвийн орлогын дийлэнх хувийг гүйцэлдүүлж байсан гаалийн албыг улам бэхжүүлэн чадваржуулж, зээл тооцоонд векселийн бэлэн бус гүйлгээний аргыг хэрэглэх болсон зэрэг чухал чухал алхмуудыг Сангийн яам зохион байгуулсан байна.

**Дөрөвдүгээрт:** Улсын үндэсний мөнгө зээлийн тогтолцоог бүрдүүлэх ажлын нэг үндсэн арга хэмжээ бол Сангийн яамнаас зах зээл дэх мөнгөний эргэлтийг эрүүлжүүлэх зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгт (Монгол төгрөг)-ийг албан татвартай болгож гүйлгээнд оруулан ханшийг нь тогтворжуулан санхүү, зээл төлбөрийн бүх тооцоог төгрөгийн нэгжид шилжүүлсэн явдал юм. Үүний үр дүнд гадаадын валютыг мөнгөн сангийн эргэлтээс шахан зайлуулсан байна.

**Тавдугаарт:** Улсын санхүү, бүртгэл тооцоо, мөнгө зээлийн салбарын үйл ажиллагааг цэгцэлж нэгдсэн тогтолцоонд оруулахын тулд Сагийн яамнаас санхүүгийн сахилга батыг сайжруулах олон талын арга хэмжээ авчээ. Энэ ажлын нэг бодитой жишээ бол улсын олон яам, албан газруудын бүх орлого зарлагыг тус бүрд нь урьдаас төлөвлөсөн дансанд бүртгүүлэн, холбогдох газраар хянан баталгаажуулж зарцуулах, эцэст нь үлдсэн дутсан хэмжээг тодорхой данс тайлангаар харуулан нэгдсэн тэнцэтгэлд нь дүн шинжилгээ хийдэг журам мөрдөгдөж эхэлсэн явдал юм.

Дээрхи зорилтуудыг улсын эдийн засгийн амьдралд хэрэгжүүлж чадсанаар үндэсний санхүү мөнгө зээлийн тогтолцоог цаашид бэхжүүлэх тэмцэлд 1930-аад оноос дор дурьдсан томоохон асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Энэ асуудлууд нь үндсэндээ Монгол улсын эдийн засгийн тусгаар тогтнолын арга хэмжээ болсон юм. Тийм асуудлуудын үндсэн бүтэц нь Монгол оронд гадаад дотоод худалдааг бие даасан онцгой эрхтэйгээр гүйцэтгэж, үндэсний аж үйлдвэрийг үүсгэн байгуулж, тээвэр зам харилцаа болгож, улсын төвлөрсөн банктэй болох үйл ажиллагаанд хамаарагдах юм. Гэвч энэ арга хэмжээ улсын эдийн засгийг хөгжүүлэх асуудлыг бүрэн төгс шийдвэрлэж хараахан чадаагүй боловч тодорхой ач холбогдлоо өгсөн байна. Дээрх арга хэмжээ нь тухайн үед Монгол оронд нийгэм улс төр, эдийн засгийн амьдралд гарсан зарим сөрөг үзэгдлүүдийн нөлөөгөөр ач холбогдлынхоо шинж чанарыг алдахад хүрч байсан. Эдгээр сөрөг үзэгдлүүдийг товчхон дурьдвал:

1. Монгол орны хөгжлийн капиталист бус замыг зөвшөөрөөгүй, хуучин феодал гэгчдийн хөрөнгийг хураах нь зохисгүй гэж үздэг "баруунтан"-ы хэсэг бүлгийн үйл ажиллагаа
2. Тэрхүү баруунтны эсрэг чиглэсэн капиталист бус хөгжлийн төлөө тэмцэгчид буюу зүүнтнүүдийн нөлөө улсын удирдлагад тодорхой байр суурь эзлэх болсон.
3. Улс төрийн хүчний хоёр талын үйлчлэлийн нөлөөгөөр Монгол орны эдийн засгийн тогтсон чиг шугамгүй байсан энэ цаг үед тодорхой дүгнэлт хийж шинэ бодлогын жилүүд гэж нэрлэгдсэн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь чухал алхам болсон
4. Монгол орныг эдийн засгийн хямралаас гаргахад ЗХУ-ын тусламж чухал үүрэг гүйцэтгэж байсан тэр үед дэлхийн хоёрдугаар дайны хор уршиг шууд нөлөөлсөн байна. Нэг ёсондоо Зөвлөлт Холбоот Улсад тохиолдсон дайны үеийн бэрхшээл манай улсад ихээхэн нөлөөлсөн билээ.

Энэхүү сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл дор Монгол улсын "...эрүүлжиж, тэнцвэржиж, дэгжин өөдлөх замдаа орж эхэлсэн санхүү эдийн засагт хүнд дарамт учирч үндэсний хэмжээгээр бүтээн үйлдвэрлэсэн баялгийнхаа талаас илүү хувийг үйлдвэрлэлийн бус хүрээнд зориулж эхэлсний улмаас тус улсын санхүү эдийн засаг дахин хямралт байдалд оржээ. Энэхүү хямралт байдлын нөхцөлд ангийн ус этгээд гэж ялгаварлагдан гадуурхагдаж байсан тайж, түшмэд, лам хувраг, сүм хийд, жас, баян малчид худалдаачдад «хувьсгалт хүчирхийлэл» хэрэглэж хэлмэгдүүлэн устгасан ба тийнхүү устгаснаараа өмч хөрөнгийг хурааж хэсгийг нь улсын орлогод авч бусдыг нь үрэгдүүлжээ. Ингэснээрээ материал баялгийн багагүй хэсгийг бүтээн үйлдвэрлэдэг аж ахуйн тогтвортой, хүч чадалтай нэгжүүдээ устгаж, улсын орлогын багагүй

хэсгийг хангадаг эх үүсвэрээ хаасан байна. Дайн түрэмгийллийн аюул заналын улмаас зайлшгүй шаардагдаж өсөн нэмэгдэж буй батлан хамгаалах хэрэгцээг дунд чадал хэмжээтэй аж ахуйгаас хангахын тулд албан татвар зэргийг аажмаар өсгөж нэмэгдүүлэх замд орсон бөгөөд энэ нь жам ёсоороо, ард түмний аж амьдрал, мөнгө барааны эргэлтийн хурд, үнэ төгрөгийн ханшид дахин нөлөөлөх болжээ. Нөгөөтэйгүүр үндэсний гол санхүүчдээ хэлмэгдүүлж, санхүү эдийн засгийн бодлогын зохистой, даацтай бодлого алдагдаж эхэлсэн юм. Тоон үзүүлэлтээр улсын төсөв, мөнгө, барааны эргэлтийн үзүүлэлтүүд ихэд өссөн боловч дотоод чанарын хувьд дахин доголдох нөхцөл үүссэн юм.

Хэдийгээр ийм хүнд нөхцөл байдал тулгарч байсан боловч дэлхийн хоёрдугаар дайны жилүүд (1941-1945)-эд Монгол улсын санхүүгийн албаны үйл ажиллагаанд хэд хэдэн өвөрмөц өөрчлөлтүүд гарсан байна. Тухайлбал:

- Санхүүгийн төлөвлөлтийг улс төр, эдийн засгийн гол цөм болгож улс ардын аж ахуйн нэгдсэн төлөвлөлтөд санхүүгийн төлөвлөлтийг зохицуулах журамд шилжсэн явдал юм.
- Ингэснээр санхүүгийн төлөвлөлт, бүртгэл тооцоонд улс, хоршооллын байгууллагын ялгаа зааг арилж, ижил нөхцөл хяналтын эрэмбэнд оржээ. Үүний үндсэн үр дагавар бол хөдөө аж ахуйн хоршооллын санхүүгийн эх үүсвэр бүрэлдэж эхэлсэн явдал юм.
- Татварын бодлогоор хувийн үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаанд тавих хяналтыг нэлээд цэгцэлж чангаруулан цар хүрээг нь хумиж эхэлсэн байна.

Энэ бүхний үр дүнд Монгол улсын санхүүгийн алба төлөвлөгөөний байгууллагаас хараат бус байдалд шилжин гол төлөв санхүүгийн хуваарилалт, хяналтын үүрэг гүйцэтгэгч байгууллага болж төлөвшсөн байна.

Гэвч басхүү Монгол улсад социалист харилцааны үндсийг бүрдүүлэх үе (1948-1960 он)-ийн амжилтын зэрэгцээгээр "...санхүүгийн алба үйлдвэрлэл санхүү, хянан шалгагч, чандлан хуваарилагчийн байр сууринд шилжсэн байна. Энэ нь таваар мөнгөний харилцаа, хувийн үйлдвэрлэл бол цаг ямагт капитализмыг төрүүлэх учир хавчин устгах ёстой, социалист нийгэм бол таваар мөнгөний харилцаа хувийн өмчөөс бүрэн ангижирсан байх ёстой гэсэн сургаал, улс төрийн эдийн засгийн үзэл баримтлалаас үүссэн гажуудал..." байсныг энд цохон тэмдэглэх нь зүйтэй юм.

Монгол улсын нийгэм эдийн засгийн бүтцэд гарсан чанарын өөрчлөлтийг тусгасан БНМАУ-ын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр санхүүгийн албаны гүйцэтгэсэн үүргийг баталгаажуулж, улс орны хөгжил дэвшилд түүний эзлэх байр суурийг тодотгон тайлбарласан байна. Энэ нь БНМАУ-ын гуравдахь үндсэн хуулийн арванзургаадугаар зүйлд "БНМАУ-ын санхүү зээлийн бодлогыг тус орны эдийн засгийн хүч чадлыг байнга зузаатгах, социалист өмчийг өсгөн нэмэгдүүлэх, социалист соёлыг хөгжүүлэх, хөдөлмөрчдийн чинээлэг аж байдлыг дээшлүүлэхэд чиглүүлнэ. Улсын санхүүгийн төлөвлөгөөг улс ардын аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөнд зохицуулан улсын төсөв болгож хуульчлан баталж нийтлэнэ. БНМАУ-ын төсвийн орлогын үндсэн эх сурвалж нь социалист аж ахуйн орлого, хуримтлал мөн" гэж тодорхойлсноор улсын санхүү зээлийн бодлогын үндсэн чиглэл гол зарчим нь хуульчлагдаж баталгаажсан байна. Монгол орны социалист эдийн засгийн төлөө тэмцлийн эхэн үеийн санхүү төсвийн албаны дүр төрхийг хуульчлан баталж байсан энэ үеийн нэгэн онцлог бол улсын эдийн засаг бүхлээрээ нийгэмчлэгдсэн өмчийн хэлбэрт шилжиж, олон улсын хөдөлмөрийн социалист хуваарьт идэвхитэй оролцож эхэлсэн явдал юм.

Гэвч энэ үеэс эхлэн "...Монгол оронд социализмыг хурдавчлан байгуулах үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч практик зорилт болгон дэвшүүлсэн нь тухайн үедээ сонгон авсан зөв зам мэт байсан боловч гаднаас тулгамдсан алдаатай зам байсан нь 30 жилийн хойно бодит байдлаар няцаагдсан..." гэдгийг бид тодорхой мэднэ. Түүхийн ийм нөхцөл байдлын дунд

оршиж байсан санхүү төсвийн алба нь улс ардын аж ахуйн салбаруудын бүртгэл тооцоог нарийвчилсан тодорхой эмх цэгцтэй болгохын хамт салбарын удирдлагын чиглэлээр хэрэгжүүлж байсан төлөвлөлт, эдийн засгийн системийг боловсронгуй болгоход үйлчилж ирсэн байна.

Нэг ёсондоо энэ үеийн санхүү төсвийн алба тухайн удирдагчдад улсын орлого, зарлагын дүн мэдээллээр хангах төдий явцуу үйлчилгээ үзүүлэгч хүчин болж хувирсан байв. Үүнийг Монгол улсын нийгэм эдийн засгийн хямралын нэг гол шалтгаан гэж тайлбарлах бүрэн үндэслэлтэй бөгөөд тэр нь нийгэм улс төрийн хүнд сурталт дэглэм болох "Социалист ардчилал"-аас иргэний ардчилсан нийгэмд шилжих шилжилтийн үе байлаа. Монгол оронд улс төр, нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоо бүрэлдэх явц дунд санхүү төсвийн төв алба болох Сангийн яамны удирдлага бүтцэд цоо шинэ өөрчлөлт гарч 1960 оноос батлан хэрэгжиж 30 жилийн туршид мөрдөж ирсэн дүрэм нь шинэчлэгджээ. Үүний үр дүнд ч Монгол орны санхүү төсвийн төв алба болсон Сангийн яам улс орондоо зах зээлийн эдийн засгийн харилцааг үүсгэж бий болгох, санхүү, бүртгэл, мөнгө зээлийн шинэ тогтолцоог бүрдүүлж эхэлсэн байна.

Энэ үндсэн дээр орчин үеийн үндэсний санхүү бүртгэл, мөнгө зээлийн тогтолцоо боловсронгуй болон хөгжиж олон улсын жишигт хүрэх нөхцөл бүрдэж байна. Өнгөрсөн арван жилийн хугацаанд Монгол улсын Сангийн яам нь санхүү төсвийн төв албаныхаа хувьд улсын санхүүгийн тогтолцоог зах зээлийн харилцаанд шилжүүлэх ажлыг гардан гүйцэтгэж зохих амжилтанд хүрлээ.

Төсвийн тухай хууль, татварын багц хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, аудитын тухай хууль, валютын зохицуулалт, үнэт цаасны хууль гэх зэрэг Монгол улсын санхүү төсвийн холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгүүдийн төсөл боловсруулах, хуульчлан баталгаажуулах, батлагдсаны дараа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан заавар аргачилалаар бүрэн хангах зэрэг зохион байгуулалтын бүх үйл ажиллагаанд Сангийн яам биечлэн оролцож байна.

Монгол улсын санхүү төсвийн албаны түүхэн үйл явцыг улсын нийгэм эдийн засгийн өөрчлөлт дэвшлийн цаг үетэй нь холбон авч үзсэн дээрхи тайлбаруудад үндэслэн тодорхой хэмжээнд дүгнэлт хийж болох юм. Тухайлбал:

**Нэгдүгээрт:** Монгол улсын санхүүгийн алба нь улс төр, нийгэм, эдийн засгийн амжилт бүтээл алдаа, гажуудал дунд 90 жилийн түүхэн хугацааг туулж өнгөрүүлэхдээ аль ч үе шатанд ялгаагүй эх орныхоо эдийн засгийн хүчин чадлыг бэхжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрээр хангах үүргээ нэр төртэй гүйцэтгэж ирсэн байна.

**Хоёрдугаарт:** Тэр утга чанараараа улсын эдийн засгийн хөгжлийн түүхэн үе хугацаанд санхүүгийн алба өөрийгөө тасралтгүй өөрчилж, байнга боловсронгуй болж дэвшин хөгжиж ирсэн байна.

**Гуравдугаарт:** Ялангуяа Монгол орны санхүү төсөв, мөнгө зээлийн харилцаа төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн нөхцөлд шилжих шилжилт улам бүр гүнзгийрч байгаа өнөөгийн нүсэр ажлын хувь заяаг санхүү төсвийн алба хариуцан ажиллах болсон нь түүний эн тэргүүний зайлшгүй шаардлага хэрэгцээний ач холбогдлыг тодорхойлж байгаа хэрэг мөн.

Ийнхүү Монгол улсын санхүү төсвийн албаны хөгжлийн түүхэн тоймыг тусгайлан авч үзсэнээр төр засгийн болон төсөвт байгууллагын хэмжээнд нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах онолын болон арга зүйн чадвар эзэмших ажлын эхлэл болно.